



“ДАЛАЙД ДУСАЛ НЭМЭР” ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Илтгэгч: А. Даваажаргал

*MA in Marketing Management, Middlesex University
BA in Business Admin, Kingston University, UK
Director of MngBridge Ltd based on entertainment industry for
Mongolian Communities*

Төслийн талаар товч танилцуулга:

Сайн сайхан амьдрахын нэг гол үндэс нь боловсрол гэдэгтэй олон хүн санал нийлэх байх. Монголд авъяас чадвартай ч ядуу зүдүүгийн хийгээд өнчин ерөөсний зовлонгоосоо болоод тэр бүр боловсрол эзэмшиж өөрсдийгөө бүрэн дүүрэн хөгжүүлж чадахгүй байгаа хүүхдүүд их байдаг. Тухайлбал Монголд 10 жилд сурч байхад үеийн хэсэг нөхөд маань мөнгөний бэрхшээлээс болоод их дээд сургуульд сурч чадахгүй хар бор ажил хийхээс аргагүй байдалд орж зарим нөхөд маань гундуухан явж байгааг хараад их харамсах сэтгэл төрдөг юм. Ийм байдлыг хараад эд нарын ганц нэгд нь ч болтугай тусалж амьдралд нь гэрэл гэгээ оруулахсан гэсэн бүр багын бодол маань явсаар энэ төсөл болж гарч ирж буй.

Нийгмийг хамраад буй тэр их асуудлуудыг бид шийдэж чадахгүй ч далайд дуслын ч болтугай нэмэр оруулая гэсэн санаанд тулгуурлан төслөө ийнхүү нэрлэсэн. Энэ хүүхдүүдэд жимс өгч нэг өдөр баярлуулахаар жимс тарих аргыг нь зааж өгөөд өдөр болгон шим ашигийг авах тэр боломжийг нээж өгөх нь илүү чухал.

Бид нэг эрэгтэй, нэг эмэгтэй төгсөх ангийн 2 хүүхдийг, тухайлбал нийслэлийн 44-р дунд сургуулийн сурагч Ган-Очир гэдэг хүү, асрамжын газарт 9-н жил амьдарсан бүтэн өнчин Хулан гэдэг охиныг тус тус сонгосон.

Энэ төслийн үр дүнд одоогоор Ган-Очир маань МУИС-ийн Хууль Эрх Зүйн ангид, Хулан маань Мандах дээд сургуулид Эдийн Засагч болон Татварийн ангид тус тус элсэн ороод амжилттай суралцаж байна.

Дүгнэлт: Хүүхдүүд бол бидний ирээдүй гэрэл гэгээ юм. Хүүхдэд урам зориг өгөх хэрэгтэй. Бидний төсөлд хамрагдсан 2 хүүхэд цаашид амьдралаа итгэлтэй, хийж бүтээх урамтай, амьдралыг гэгээлэг өнгөөр хардаг сайн хүмүүс болон төлөвшөнө гэдэгт бид итгэлтэй байна.

1. Оршил

Иргэн баян бол улс баян гэдэг. Монгол улсын хэмжээнд 2 сая 700 гаран иргэн л байдаг. Харин тэр иргэдийн хэдэн хувь нь өнөөдөр нийгэмд баталгаатай амьдарч байна. монгол улсын эдийн засгийн хөрөлт бууралтаас шалтгаалан өнөөгийн монголын амьдрал нийгмийн доод давхрагад очитлоо буурчээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 108,000 буюу £48 байна. Сард хөдөлмөрлөөд олох цалин. Гэвч үүнийг зөвхөн тэр ажилчин өөртөө зарцуулахгүй. Ард нь ар гэр үр хүүхэд нь байгаа. Ингээд бодохоор дэндүү харамсалтай байгаа биз. Ийм учраас өнөөдөр монголд хүүхдийн сургууль завсардалт маш их байна. Хүүхдүүд 10-н жилийнхээ сургуулийг төгссөнч цааш сурая гэхэд сургалтын төлбөрийн мөнгө байхгүй учир сурч чадахгүйд хүрдэг. Ингээд ажилгүйчүүдийн эгнээ нэмэгдэж тэд гудамжинд гарч амьдрахын эрхээр хулгай хийж буруу замаар ордог. Өөр ажил хийхээр боловсролгүй гээд халгаахгүй. Хүний амьдралийн хамгын аз жаргалтай үе бол хүүхэд нас. Гэтэл өнөөдөр монголын хүүхдүүд тийм биш байна. Тэд ядарч туйлдатлаа ажиллаж амьдралаа залгуулдаг. Mngbridge group-с энэхүү байдлыг бага ч атугай хөнгөлөх зорилгоор өнчин ядуу 2 хүүхдийг бүх зардлыг нь дааж 4н жил их дээд сургуульд тэтгэлэгтэйгээр сургаж амьдралыг нь өөрчлөж өөд татах, урам өгөх зорилгоор энэхүү төслийг боловсруулан гаргалаа.

2. Үндсэн хэсэг

Уг төслийг хэрэгжүүлснээр 2 хүүхдийн ирээдүйд сайнаар нөлөөлж цаашид ажиллаж хөдөлмөрлөх урам зоригийг нь бадраагаад зогзохгүй дэвжин дээшлэх гарааг нь тавьж өгч байгаа билээ. Монгол улсын нийгмийн доройтол, санхүүгийн уналт зэргээс шалтгаалан маш олон хүн ядуурал хэмээх харанхуй нүхэнд өдөр ирэх тусам унасаар байгаа билээ. Монгол улсын хэмжээнд хүүхдийн гэсэн тодотголтой олон арван байгууллагууд байдаг. Эдгээр байгууллагууд “хүүхдийн” гэсэн нэрийдлээр олон сая төгрөгийн зээл буцалтгүй тусламж авч байгаа хэдий ч үнэн хэрэгтээ хүүхдэд тусч, гар дээр нь очиж байгаа нь ховорхон. 2004 онд МУ-н эдийн засаг 2% өссөн статистик судлагаа гарсан. Гэсэн хэдий ч эдийн засгын өсөлт нийгмийн давхрагад нэгээхэнч хүрч чадаагүй. 2006 оны сүүлээр хүүхэд бүрт улсаас 10.000-н төгрөг сар бүр өгөх хууль гарсан боловч энэ хууль нь заалтандаа “МУ-н хүүхэд бүрт сар болгон ХҮҮХДИЙН МӨНГӨ олгогдохоор болов. Уг мөнгийг хүүхэд бүрийн нэрийн дансанд хадгалаж 18 нас хүрхэд нь бөөнөөр нь өгнө” гэж тусгасан. 18 нас хүртэл нь тэр банкинд хадгална. Гэтэл үнэн хэрэгтээ хүүхдийн мөнгө гэсэн нэрийдлээр банкуудийн эргэлдэх хөрөнгийн эх үүсвэрийг бий болгожээ. Үүнийг зарим улс төрчид эсэргүүцсэнээр 2007 оноос МУ-н 18 нас хүртлэх бүх хүүхдэд сар бүр 3000-н төгрөг бэлнээр өгөх болсон нь хүүхдүүдээ харсан анхны том ажил болсон. Монголд хөдөлмөрийн бэрхшээлтэй, өнчин, нэн ядуу хүүхдүүд маш их байдаг. Мөн хөдөөгийн хүүхдүүд. Сурах боломжгүй,

сургалтын байр танхимгүй мөн дотуур байрны асуудлаас болоод сургууль завсардан гарах тохиолдол хөдөөгүүр элбэг. Тиймээс зөвхөн өөрийн нэрээ л бичиж чаддаг л байвал болдог гэсэн ойлголтийг авч хаян ирээдүйгээ зөвхөн хонь хариулхаас өөрөөр төсөөлдгүй хүүхдүүдийг өрөвдмөөр. Эцэг эхийн ядуу тарчиг байдлаас болж маш олон авьяаслаг оюунлаг хүүхдүүд сурахыг хүссэнч ар гэрийн боломжгүйгээс сургуулиа орхин гудамжинд гарч тамхи заран өөрийнхөө амьдралыг балладаг. Хүүхэд л бол хүүхэд шүү дээ. Сургуульдаа явж инээж хөөрч, аав ээждээ эрхлэн, үеийнхээ хүүхдүүдтэй хөгжилдөн тоглохын оронд гадаа гудамжинд хэн надаас хэн тамхи авах бол хэмээн өрөвдөнгүй, царайчлангүй нүдээр харж зогсох бяцхан хүүхдийг та харж байсан уу?

Нэгэн удаа би зах дээр тамхи тор уут зардаг 6 настай хүүхдийн талаар үзсэн юм. 2 настай дүүгээ хажуудаа дагуулсан. Тэр хүү 6-хан настай байж хэнээр ч заалгаагүй хэрнээ 10-н жилийн 8р ангийн тоог хөнгөхөн бодчихдог. 1-с 2 сая-н дотор цээжээр үржүүлж хувааж нэмэж хасаж чаддаг. Тэрийг нь томчууд сонирхон үзэж одоо энэ мөрөөдлөө өгдөг тухай үзлээ. Энэ хүү үнэхээр гайхалтай авьяастай гэвч тэр ядуу учраас хэзээ ч сургуульд сурч чадахгүй. Энэ мэтчилэн орхигдсон хүүхдүүд цөөнгүй байгаа. Мөн асрамжинд байгаа буюу өнчин хүүхдүүд. Эцэг, эхгүй өөрийн хэнч байхгүй өнчин хүүхдүүд бас сурах нөхцөлөөр хязгаарлагдмал байдаг.

Миний өөрийн багын мөрөөдөл маань өнчин, ядуу хүүхдүүдийг сургуульд сургаж мэдлэг боловсрол эзэмшүүлэх, тусламж өгөх, тусламжын сан байгуулах билээ. Гэвч энэ мөрөөдлөө биелүүлж чадахгүй байсны эцэст одоо энэ мөрөөдлөө биелүүлэх боломж бололцоо олдож 1 өнчин 1 нэн ядуу хүүхдийг 4 жилийнх нь бүрэн сургалтын зардал, байрны зардал, сар бүрийн тэтгэлэгээр хангаж сургахаар болсон юм. Би ер нь хүнд мөнгөөр туслахгүй харин яаж мөнгө олж болох вэ гэдэг аргыг нь зааж өгсөн нь тэр хүнд тэрхэн зууртаа мөнгөөр тусалснаас илүү дээр гэж үздэг. Тиймээс 2 хүүхдийг шалгаруулан өөрийн зардлаар их сургуульд сурган мэдлэг боловсролтой нийгэмд тустай нэгэн болон төлөвшихөд өөрийн хувь нэмрээ оруулан багын мөрөөдлөө биелүүлж байна.

3. Төслийн зорилго:

- Энэ хэцүү шилжилтийн нийгэмдээ дусал ч гэсэн нэмэр болох
- Төр засагийнхаа нуруунаас дусал ч гэсэн ачааг хөнгөлөх
- Гадаадад сурч, ажиллаж бас Business хийж байгаа үе-ийн залуучууд дундаа үлгэр жишээ болох.

4. Төслийн үйл явц:

Бид тусгай баг гарган нийсэллийн 44 дүгээр сургууль дээр очиж хичээлийн эрхлэгч болон бусад багш нартай уулзаж онц сурдаг амьдралын боломж муутай 11 дүгээр ангидаа орсон Ган-Очир гэдэг залууг сонгосон юм. Ган-Очир маань 10 дугаар ангиа онц дүнтэй төгссөн бөгөөд ээжтэйгээ хоёулаа байдаг бөгөөд айлийн нэг өрөө хөлсөлж амьдардаг юм.

Бид мөн тусгай баг гарган 44-р сургуулийн хажуу харалдаа орших асрамжийн газар дээр очиж хариуцсан захирал болон бусад ажилчиддаас нь санал асуулга авсны үндсэн дээр Хулан гэдэг бүтэн өнчин охинийг сонгосон юм. Хулан маань 11 дүгээр ангиа төгсөөд л асрамжийн газраасаа заавал гарах ёстой бөгөөд өөрийн гэсэн танил садан байхгүй их хэцүү байдалд орсон байсан бөгөөд энэхүү төслийн ачаар сэтгэл санаа нь бага ч гэсэн тайвширсан байхаа гэж бид найдаж байгаа. Энэ охин маань сургуульдаа онц сурдаг бөгөөд уралдаан тэмцээнд байнга маш амжилттай оролцож байсан охин байгаа.

• Хөрөнгө хуримтлалын шат:

Бид 9 сарын 1нээс эхлээд хуримтлал цуглуулж эхэлсэн бөгөөд энэхүү санхүүгээ хүмүүсээс гуйж биш тодорхой хэмжээний “party” болон “show” зохион байгуулж, олсон оролгоосоо энэ хуримтлалаа бүрдүүлсэн ба үүний дүнд бидний нийт цуглуулах хуримтлал маань £4000 болсон юм. 9 сарын 1нд “Peace Party”-р олсон ашиг £600 болсон юм.

Дараах арга хэмжээнүүдээс цугларсан мөнгөнөөс тодорхой хувийг төсөлдөө оруулсан юм. Үүнд:

- 2008 оны 10 сарын 23нд Kiwi-н тоглолтын өөрсдийн цэвэр ашгийн £1600
- 2008 оны 11 сарын 26нд Freezone-ний Төрөөгийн бие даасан тоглолтоор олсон өөрсдийн цэвэр ашгийн £300
- 2008 оны 12 сарын 29нд болсон Монголчуудын шинэ жилийн “party”- наас үлдсэн £1500-г бид цуглуулсан юм. Нийт цуглуулах ёстой хөрөнгөө (£4000) бид ийнхүү босгож авсан юм.

• Хуримтлалын дараах шат:

Бидний дараагийн шат сонин сэтгүүл болон TV- р “Далайд Дусал Нэмэр” төсөлөө олон түмэнд танилцуулах явдал байсан юм. Бидний сонгосон Ган-Очир болон Хулан 2 маань 11 -р ангиа төгсөж байсан. Тэр хоёр тус бүрдээ их сургуулиа сонгоод бид тэр их сургуульд нь 4 жилээр төлбөр тооцоог хийхээр төлөвлөгөө гаргасан юм.

7. Үр дүн

Энэ төслийн үр дүнд одоогоор Ган-Очир маань МУИС-ийн Хууль Эрх Зүйн ангид, Хулан маань Мандах дээд сургуулид Эдийн Засагч болон Татварийн ангид тус тус элсэн ороод амжилттай суралцаж байна.

8. Дүгнэлт

“ДАЛАЙД ДУСАЛ НЭМЭР” төслийг бид санаачлан хийснээр сурах сонирхолтой, амьдралын олон өнчин хүүхдүүдийн багахан хэсэгт ч болов туслаж амьдралыг нь өөрчлөх гэрэл гэгээ урам дэм өгөхийг зорилгоо болгосон юм. Өөрийнхөө буруугаас биш хэрнээ оюун ухаан, сэтгэл санаа, хүүхэд насаараа хохирч буй тэр өчүүхэн эмзэг цэцэгсийг бид өрөвдөн хайрлаасай, бидний энэхүү ажлыг дэмжиж өөр олон хүн хүүхдүүдийг боловсролтой болход нь тусалсан бүх хүмүүст төслийн багын өмнөөс баярласан талархаснаа илэхийлэх гэсэн юм..

Бид өөрсдөө хүүхэд насаа тойрч өнгөрөөгүй дайрч өнгөрсөн. Тийм учраас хүүхдүүдэд цэцэг авч өгөх биш цэцэгийг яаж тарих аргыг нь зааж өгөхтэй адил тэднийг оюунлаг болгохын төлөө чадлаараа туслахыг уриалья. Хүүхдүүд бол бидний ирээдүй гэрэл гэгээ юм. Хүүхдэд урам зориг өгөх хэрэгтэй. Бидний төсөлд хамрагдсан 2 хүүхэд цаашид амьдралаа итгэлтэй, хийж бүтээх урамтай, амьдралыг гэгээлэг өнгөөр хардаг сайн хүмүүс болон төлөвшөнө гэдэгт бид итгэлтэй байна